

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/03/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт.....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/159

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 94,7 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

019020289

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,460,808,056.49	1,827,232,617.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,046,298.23	36,868,428.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,046,298.23	36,868,428.75
3121	Төгрөг	3,046,298.23	36,868,428.75
31211	Төрийн сангийн харилцах	3,046,298.23	36,868,428.75
33	АВЛАГА	40,031,012.02	544,961,010.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,426,012.02	2,520,100.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	35,605,000.00	542,440,910.40
35	БАРАА МАТЕРИАЛ	1,417,730,746.24	1,245,403,178.48
351	Түүхий эд материал	1,145,766,594.72	993,781,758.39
35110	Тусгай зориулалттай материал	229,196,445.53	246,281,224.46
35130	Эм боох материал	916,570,149.19	747,500,533.93
354	Хангамжийн материал	271,964,151.52	251,621,420.09
35410	Бичиг хэргийн материал	1,393,800.00	830,000.00
35420	Аж ахуйн материал	2,094,920.00	51,520.00
35430	Сэлбэг хэрэгсэл	521,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	5,349,720.00	768,040.00
35460	Хүнсний материал	6,633,493.10	1,926,445.59
35470	Бусад хангамжийн материал	255,971,218.42	248,045,414.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,556,673,169.12	14,811,980,283.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,556,673,169.12	14,811,980,283.04
392	Биет хөрөнгө	14,864,556,296.73	14,119,915,143.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,777,319,918.00	8,299,111,702.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-867,025,438.96	-1,087,258,897.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	455,831,119.00	589,330,057.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-223,028,280.31	-223,631,711.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,964,332,387.89	13,227,683,311.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,563,787,362.19	-6,948,552,068.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	476,418,167.10	442,719,422.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-223,813,784.32	-228,284,656.14
39209	Зам, гүүрийн байгууламж	212,268,121.00	212,268,121.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-169,217,143.20	-182,900,802.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,522,224.00	65,522,224.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-40,668,631.28	-46,496,558.04
39217	Ном	405,000.00	405,000.00
393	Биет бус хөрөнгө	692,116,872.39	692,065,139.19
39301	Програм хангамж	77,990,700.00	78,917,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-75,323,827.61	-76,302,560.81
39303	Бусад биет бус хөрөнгө	689,450,000.00	689,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,017,481,225.61	16,639,212,900.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	111,237,584.60	837,545,979.83
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	111,237,584.60	837,545,979.83
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	111,237,584.60	837,545,979.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,906,243,641.01	15,801,666,920.99
51	Засгийн газрын хувь оролцоо	16,906,243,641.01	15,801,666,920.99

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,497,859,191.42	4,497,859,191.42
51101	Өмч: - төрийн	4,497,859,191.42	4,497,859,191.42
512	Хуримтлагдсан үр дүн	7,928,523,583.98	6,823,946,863.96
51210	Өмнөх үеийн үр дүн	7,928,523,583.98	7,928,523,583.98
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,104,576,720.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,479,860,865.61	4,479,860,865.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИИН ДҮН VI=IV+V	17,017,481,225.61	16,639,212,900.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,827,254,018.36	14,893,425,930.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,525,422,294.46	2,549,961,160.14
120	Нийтлэг татварын бус орлого	6,525,422,294.46	2,549,961,160.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	444,867,160.00	835,473,820.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,867,160.00	528,353,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	307,120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,301,831,723.90	12,343,464,770.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10,301,831,723.90	12,343,464,770.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,301,831,723.90	12,343,464,770.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,885,155,771.01	15,974,487,240.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,885,155,771.01	15,974,487,240.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,877,165,965.01	15,949,997,792.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,602,698,901.78	7,183,079,733.23
210101	Үндсэн цалин	3,308,666,522.98	3,917,551,115.38
210102	Нэмэгдэл	1,800,131,161.80	2,559,415,501.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	152,960,433.00	269,981,203.73
210104	Урамшуулал	339,310,595.00	436,131,912.47
210105	Гэрээт ажлын хөлс	1,630,189.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	703,104,358.93	899,023,059.63
210201	Тэтгэврийн даатгал	486,084,759.21	629,863,040.17
210202	Тэтгэмжийн даатгал	56,970,184.46	73,782,968.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,834,778.90	59,695,291.82
210204	Ажилгүйдлийн даатгал	10,441,197.04	12,307,151.75
210205	Эрүүл мэндийн даатгал	104,773,439.32	123,374,607.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	768,252,705.80	883,744,526.61
210301	Гэрэл, цахилгаан	97,723,096.00	161,852,446.49
210302	Түлш, халаалт	484,573,796.80	569,443,036.12
210303	Цэвэр, бохир ус	185,955,813.00	152,449,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	275,165,421.30	349,180,330.41
210401	Бичиг хэрэг	42,898,990.00	39,173,870.00
210402	Тээвэр, шатахуун	103,183,280.00	122,049,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,949,847.30	9,009,526.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	99,707,308.00	102,953,130.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,425,996.00	75,994,603.92

2105	Нормативт зардал	3,164,224,310.03	3,856,215,098.28
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,913,817,127.13	3,503,749,373.04
210502	Хоол, хүнс	233,268,382.90	352,465,725.24
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,138,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,509,878.00	276,997,209.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,088,770.00	1,182,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,241,000.00	00.00
210604	Урсгал засвар	133,180,108.00	275,815,209.00
2107	Томилолт, зочны зардал	5,472,000.00	8,808,000.00
210702	Дотоод албан томилолт	5,472,000.00	8,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,621,731.00	154,713,949.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,685,750.00	135,451,210.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,844,000.00	3,040,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	727,650.00	698,395.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	790,574.00	395,944.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,188,330.00	4,768,800.00
210807	Газрын төлбөр	2,019,927.00	3,029,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	112,500.00	225,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	6,874,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,144,116,658.17	2,338,235,886.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,339,500.00	3,120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,140,777,158.17	2,335,115,886.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,989,806.00	24,489,448.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,989,806.00	24,489,448.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,989,806.00	24,489,448.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,942,098,247.35	-1,081,061,309.59
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	23,515,410.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	23,515,410.43
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-23,515,410.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,942,098,247.35	-1,104,576,720.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	11,708,676,621.90	12,672,102,680.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	444,867,160.00	835,473,820.00
120	Нийтлэг татварын бус орлого	444,867,160.00	835,473,820.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	444,867,160.00	835,473,820.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	444,867,160.00	528,353,820.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	307,120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,263,809,461.90	11,836,628,860.40
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,263,809,461.90	11,836,628,860.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,263,809,461.90	11,836,628,860.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	11,559,222,956.14	12,376,729,875.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,559,222,956.14	12,376,729,875.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,550,385,150.14	12,352,240,427.88

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,597,619,752.08	7,181,173,821.36
210101	Үндсэн цалин	3,303,587,373.28	3,915,645,203.51
210102	Нэмэгдэл	1,800,131,161.80	2,559,415,501.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	152,960,433.00	269,981,203.73
210104	Урамшуулал	339,310,595.00	436,131,912.47
210105	Гэрээт ажлын хөлс	1,630,189.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	703,104,358.93	899,023,059.63
210201	Тэтгэврийн даатгал	486,084,759.21	629,863,040.17
210202	Тэтгэмжийн даатгал	56,970,184.46	73,782,968.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,834,778.90	59,695,291.82
210204	Ажилгүйдлийн даатгал	10,441,197.04	12,307,151.75
210205	Эрүүл мэндийн даатгал	104,773,439.32	123,374,607.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	888,252,705.80	806,209,068.43
210301	Гэрэл, цахилгаан	97,723,096.00	161,852,446.49
210302	Түлш, халаалт	604,573,796.80	491,907,577.94
210303	Цэвэр, бохир ус	185,955,813.00	152,449,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	271,650,355.30	302,546,273.49
210401	Бичиг хэрэг	30,955,390.00	31,163,350.00
210402	Тээвэр, шатахуун	108,553,350.00	117,716,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,949,847.30	9,009,526.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,723,748.00	40,756,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	82,468,020.00	103,900,627.00
2105	Нормативт зардал	3,802,769,469.03	2,704,337,213.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,523,737,511.03	2,339,369,266.24
210502	Хоол, хүнс	236,812,508.00	346,347,197.33
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,219,450.00	18,620,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	189,091,218.00	258,217,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,302,430.00	26,588,300.00
210602	Тавилга	00.00	427,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,722,000.00	5,850,000.00
210604	Урсгал засвар	126,066,788.00	225,352,030.00
2107	Томилолт, зочны зардал	5,472,000.00	8,808,000.00
210702	Дотоод албан томилолт	5,472,000.00	8,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,755,791.00	184,347,481.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,305,450.00	152,071,242.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,844,000.00	3,040,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	727,650.00	698,395.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	790,574.00	395,944.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	231,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,282,330.00	17,131,900.00
210807	Газрын төлбөр	2,019,927.00	3,029,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	112,500.00	225,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,420,360.00	7,524,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,669,500.00	7,577,680.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,330,000.00	4,457,680.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,339,500.00	3,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,837,806.00	24,489,448.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	8,837,806.00	24,489,448.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,837,806.00	24,489,448.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	149,453,665.76	295,372,804.52
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	152,683,956.00	261,550,674.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	152,683,956.00	261,550,674.00
2200	Дотоод эх үүсвэрээр	152,683,956.00	261,550,674.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	152,683,956.00	261,550,674.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-152,683,956.00	-261,550,674.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,230,290.24	33,822,130.52
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,276,588.47	3,046,298.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,046,298.23	36,868,428.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,166,882,791.76	10,144,602,848.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,166,882,791.76	10,144,602,848.79
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-185,101,049.28	-185,101,049.28
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	7,928,523,583.98	16,906,243,641.01
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	7,928,523,583.98	16,906,243,641.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	7,928,523,583.98	16,906,243,641.01
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,104,576,720.02	-1,104,576,720.02
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	6,823,946,863.96	15,801,666,920.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,309,887,800.00	12,638,280,549.88	671,607,250.12	95.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,309,887,800.00	12,638,280,549.88	671,607,250.12	95.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,285,320,000.00	12,613,791,101.88	671,528,898.12	94.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,204,432,600.00	7,181,173,821.36	23,258,778.64	99.7
210101	Үндсэн цалин	3,885,333,400.00	3,915,645,203.51	-30,311,803.51	100.8
210102	Нэмэгдэл	2,338,657,900.00	2,559,415,501.65	-220,757,601.65	109.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	243,541,700.00	269,981,203.73	-26,439,503.73	110.9
210104	Урамшуулал	736,899,600.00	436,131,912.47	300,767,687.53	59.2

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	900,554,200.00	899,023,059.63	1,531,140.37	99.8
210201	Тэтгэврийн даатгал	612,376,800.00	629,863,040.17	-17,486,240.17	102.9
210202	Тэтгэмжийн даатгал	72,044,300.00	73,782,968.44	-1,738,668.44	102.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	57,635,500.00	59,695,291.82	-2,059,791.82	103.6
210204	Ажилгүйдлийн даатгал	14,408,900.00	12,307,151.75	2,101,748.25	85.4
210205	Эрүүл мэндийн даатгал	144,088,700.00	123,374,607.45	20,714,092.55	85.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	916,157,400.00	806,209,068.43	109,948,331.57	88.0
210301	Гэрэл, цахилгаан	120,687,500.00	161,852,446.49	-41,164,946.49	134.1
210302	Түлш, халаалт	596,046,800.00	491,907,577.94	104,139,222.06	82.5
210303	Цэвэр, бохир ус	199,423,100.00	152,449,044.00	46,974,056.00	76.4
2104	Хангамж, бараа материалын зардал	311,870,800.00	304,416,273.49	7,454,526.51	97.6
210401	Бичиг хэрэг	31,894,800.00	31,163,350.00	731,450.00	97.7
210402	Тээвэр, шатахуун	120,000,000.00	117,716,520.00	2,283,480.00	98.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,576,000.00	9,009,526.49	1,566,473.51	85.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,600,000.00	40,756,250.00	7,843,750.00	83.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,800,000.00	105,770,627.00	-4,970,627.00	104.9
2105	Нормативт зардал	3,140,597,800.00	2,708,657,213.57	431,940,586.43	86.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,768,287,200.00	2,343,689,266.24	424,597,933.76	84.7
210502	Хоол, хүнс	353,376,600.00	346,347,197.33	7,029,402.67	98.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,934,000.00	18,620,750.00	313,250.00	98.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	524,229,500.00	491,189,930.00	33,039,570.00	93.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	261,630,000.00	241,662,200.00	19,967,800.00	92.4
210602	Тавилга	17,400,000.00	16,505,700.00	894,300.00	94.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,850,000.00	5,850,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	239,349,500.00	227,172,030.00	12,177,470.00	94.9
2107	Томилолт, зочны зардал	8,851,000.00	8,808,000.00	43,000.00	99.5
210702	Дотоод албан томилолт	8,851,000.00	8,808,000.00	43,000.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,293,000.00	206,736,055.00	63,556,945.00	76.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,900,000.00	172,032,816.00	49,867,184.00	77.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,294,000.00	3,040,000.00	4,254,000.00	41.7
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	698,395.00	301,605.00	69.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892,000.00	395,944.00	496,056.00	44.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,000.00	231,000.00	125,000.00	64.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,881,400.00	19,558,900.00	322,500.00	98.4
210807	Газрын төлбөр	5,669,600.00	3,029,600.00	2,640,000.00	53.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,500,000.00	225,000.00	3,275,000.00	06.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,800,000.00	7,524,400.00	2,275,600.00	76.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,333,700.00	7,577,680.40	756,019.60	90.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,046,200.00	4,457,680.40	-1,411,480.40	146.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,287,500.00	3,120,000.00	2,167,500.00	59.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,567,800.00	24,489,448.00	78,352.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,567,800.00	24,489,448.00	78,352.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,567,800.00	24,489,448.00	78,352.00	99.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,067,767,800.00	12,672,102,680.40	395,665,119.60	97.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,463,067,800.00	11,836,628,860.40	626,438,939.60	95.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,463,067,800.00	11,836,628,860.40	626,438,939.60	95.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	604,700,000.00	835,473,820.00	-230,773,820.00	138.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	604,700,000.00	528,353,820.00	76,346,180.00	87.4

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	307,120,000.00	-307,120,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	3,046,298.23	-3,046,298.23	
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	36,868,428.75	-36,868,428.75	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	356.00	318.00	38.00	
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	00.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	297.00	259.00	38.00	
620003	Үйлчлэх ажилтан	57.00	57.00	00.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны зорилго нь ард иргэдэд эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн тусламж үйл ажиллагааг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Нэгдсэн эмнэлэг 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 17,081.3 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 3,110.7, амбулаторийн үзлэг 12,428.8, идэвхтэй хяналтын үзлэг 1,541.8 хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 546.9 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 567 буюу 10,4%, осол гэмтлийн дуудлага 126 буюу 2,3%-ийг эзэлж байна. Нийт 816.5 өвчтөн 6,402.5 ор хоног ашиглан хэвтүүлэн эмчлүүлсэн ба дундаж ор хоног 7-8 өдөр байна.

Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгооны зохион байгуулалт, ач холбогдол, иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдэд байгууллагын вэб сайт болон фэйсбүүк хуудсанд мэдээлэн ажилласан байна.

Тус байгууллага нь 356 батлагдсан орон тоотой боловч 2023 онд 318 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд: Ерөнхий менежер 1, Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга 1, Үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга 1, Ерөнхий нягтлан бодогч 1, Тооцооны ня-бо 3, Касс, нярав 1, Аж ахуйн нярав 1, Хүний нөөц менежер 1, Хүний нөөцийн ажилтан 1 орон тоогоор ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2023 оны 11 сард Төв аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтад хамрагдаж 93%-тай дүгнэгдсэн. Мөн 2023 оны 7-р сард Төв аймгийн санхүү хяналт, аудитын албанаас 2021-2022 оны санхүүгийн тайланд хяналт шалгалт хийж шилэн дансны мэдээлэл, Нягтлан бодох бүртгэл, анхан шатны бүртгэл хөтлөлт 84,6% буюу шаардлагын түвшинд гэж дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 378,268.3 мянган төгрөгөөр буюу 2,2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,046.3	36,868.4	33,822.1
Авлага	40,031.0	544,961.0	504,930.0
Урьдчилж гарсан зардал, тооцоо			
Бараа материал	1,417,730.7	1,245,403.2	-172,327.5
Үндсэн хөрөнгө	14,864,556.3	14,119,915.1	-744,641.2
Нийт хөрөнгө	17,017,481.2	16,639,212.9	-378,268.3
Өр төлбөр	111,237.6	837,546.0	726,308.4

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,906,243.6	15,801,666.9	-1,104,576.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,017,481.2	16,639,212.9	-378,268.3

2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 36,868.4 мянган төгрөг болж өмнөх оноос 33,822.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн цалин, нэмэгдэл зэрэг зардал хэмнэлт гарснаас шалтгаалжээ.

2023 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 542,440.9 мянган төгрөгийг төлбөртэй үйлчилгээний авлага дансанд, Нийгмийн даатгалын шимтгэлд ажил олгогчоос төлөх шимтгэлийн илүү төлөлт 2,520.1 мянган төгрөгийг ажиллагсадтай холбогдсон авлагын дансанд тус тус бүртгэж тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,245,403.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 12,1%-иар буюу 172,327.5 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 4,341,278.3 мянган төгрөгийн бараа материалын орлого авсан. төсвийн хөрөнгөөр 3,979,178.7 мянган төгрөг, хандив тусламжаар 362,099.6 мянган төгрөг Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд өөрийн үйл ажиллагаанд материалын данстуудаар нийт 4,090,721.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/69 тоот тушаалаар 282,556.3 мянган төгрөгийн эм, боох материал /Коронавирус цар тахлын үеэр хандив тусламжаар ирсэн бараа материал хугацаа нь дууссан тул акталсан/ 61,646.1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 29,223.4 мянган төгрөгийн тусгай зориулалттай материалыг тус тус акталж дансны хасалт хийснээс шалтгаалж Бараа материалын эцсийн үлдэгдэл өмнөх оноос 172,327.5 мянган төгрөгөөр буурсан.

Үндсэн хөрөнгө данс 744,641.2 мянган төгрөгөөр буюу 4,8 %-иар буурсан нь:

Тайлант хугацаанд 261,550.6 мянган төгрөгийн хөрөнгийг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч, 1,352,387.7 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМЯ болон бусад хандив тусламжаар авч бүртгэлд авч нийт 1,613,938.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод бүртгэн авсан байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн а/60 тоот тушаал, 2023 оны 12 дугаар сарын 28-ны А/68 тоот тушаалаар хандив тусламжаар ирсэн 1,352,387.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүртгэлд авч, шаардлагатай тасаг нэгжүүдэд хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 сарын 4 өдрийн 02 тоот тогтоолоор Амбулаторийн А, Б блокын дээвэр муудсантай холбоотой их засварт 371,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, тус дээврийн засварын ажилд 349,783.1 мянган төгрөгийн гүйцэтгэл хийгдэж үндсэн хөрөнгийн бүртгэлд капиталжуулан бүртгэсэн байна.

Мөн Катар улсын иргэний хандивын хөрөнгөөр Хүүхдийн тасгийн засварын ажилд 69,120.0 мянган төгрөгийг зарцуулсан. Үндсэн хөрөнгийг өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулсан дүн 2,335,115.9 мянган төгрөг байна

Тайлант онд Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус ҮИ-р хуралдааны 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн “Хөрөнгө шийдвэрлэх тухай” 06-р тогтоолоор Автомашин 64,597.4 мянган төгрөг, Тоног төхөөрөмж 593,425.4 мянган төгрөг, Тавилга эд хогшил 70,045.5 мянган төгрөг нийт 728,068.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт: 2023 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 12,463,067.8 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 604,700.0 мянган төгрөг нийт зарлагыг 13,067,767.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналыг 13,374,887.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 13,374,887.8 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 200,000.0 мянган төгрөгийг ЭМЯ-аас, 69,120.0 мянган төгрөгийг Катар улсын иргэний хандивын орлого, 38,000.0 мянган төгрөгийг ЭМГ-аас /в,с вирус илрүүлэх оношлуурт/ тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 12,638,280.5 мянган төгрөг буюу 95,0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 671,528.9 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин, нэмэгдэл болон цалин хөлстэй холбоотой зардлыг 23,253.8 мянган төгрөгөөр, бусад хангамжийн бараа материал зардлыг 7,454.5 мянган төгрөгөөр нормативт зардлыг 431,940.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Данс код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ- үйл ажиллагаа	13,309,887.8	12,638,280.5	671,607.2	95,0
80101	Үндсэн үйл ажиллагаа- арга хэмжээ	13,285,320.0	12,306,671.1	978,648.9	92,6
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж- арга хэмжээ	24,567.8	24,489.4	78,3	99.7
71602	Туслах үйл ажиллагааны орлого		307,120.0	307,120.0	100,0
		13,309,887.8	12,638,280.5	671,607.2	95

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ-үйл ажиллагаа	2023,12,31	100	97	13,067,767.8	12,672,102.7
2	Үндсэн үйл ажиллагаа-арга хэмжээ	2023,12,31	100	94,6	13,043,200.0	12,340,493.3
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж- арга хэмжээ	2023,12,31	100	99.7	24,567.8	24,489.4

Хэрэгжилт дутуу арга хэмжээнүүд байхгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган Нэгдсэн эмнэлгийн даргаар батлуулан төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн системд нэг бүрчлэн шивж оруулан цахим тендер явуулах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна. 2023 онд Эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, тээвэр шатахуун, Лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар нээлттэй тендер шалгаруулалт 4, Хангамжийн материал худалдан авахаар харьцуулалтын аргаар 1 тендерийг тус тус зарлан явуулсан байна. Тээвэр шатахуунд нээлттэй тендер зарлаж Ник ХХК шалгарч гэрээ байгуулан 109.0 сая төгрөгийн тээвэр шатахуунаар ханган ажилласан.

Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр шалгарсан Монос трейд ХХК, Айвико хэлт интернэшнл ХХК, Монфа ХХК, Эрүүл энхийн гольдрил ХХК, Нахиа ХХК, Азифарм ХХК, Еврофарм ХХК, Мөнхийн тун ХХК, Энто ХХК, Монгол фарм ХХК, МЭИК ХХК, Биомед ХХК,Торгон туул ХХК, Медиконт ХХК, Цомбо ХХК компаниудаас 94 нэр төрлийн 396,229.0 мянган төгрөгийн эм,бэлдмэл эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан байна.

Мөн Цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр шалгарсан 15 эмийн компанитай гэрээ байгуулан эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийн ажилласан байна. Лабораторийн тоног төхөөрөмж: Лабораторийн тасагт иммунологи болон биохимийн бүрэн автомат анализаторыг 134.4 сая төгрөгөөр худалдан авахаар Нээлттэй тендер зарлаж Баянгол мед ХХК 134.2 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулан ажилласан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар, нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №55 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 11,710,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 234,200.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 187,360.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллан, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 онд 356 орон тоотой ажиллахаас 318 орон тоотой ажиллаж сувилагч, эмч нарын орон тоо дутуу ажилласнаар нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын төсөв 23,258.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн. Байр ашиглалттай холбоотой зардлыг 109,948.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлын 33,039.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлын 7,454.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалттай гэж үзсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 4 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	
Акт	2	2,007.3	2	2,007.3	100,0	
Албан шаардлага	3	846,438.9	3	846,438.9	100.0	
Зөвлөмж	2	3,350.2	1	3,350.2	100	
Нийт дүн			1		100	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,000.0 мянган төгрөгийн 1 алдаа, 282,556.3 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс аудитын явцад 1,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 282,556.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

1.Зардлын данстай холбоотой

Шинээр орсон ажилтны ээлжийн амралт олгох хугацааг дутуу тооцож олгосон 1,000.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулснаас хойш 6 сар болсон бол ээлжийн амралт эдлэх эрх үүснэ” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт:

1. Зардлын данстай холбоотой

Тайлант онд тэтгэвэрт гарсан хүнийг гэрээний дагуу авч ажиллуулж байх хугацаанд ээлжийн амралтын тооцоог холбогдох хуулийн дагуу бодож олгоогүй 300.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д “Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь:

МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн буруутай этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны жилийн эцсээр тус эмнэлэгт 282,556.3 мянган төгрөгийн эрүүл мэндийн яам болон хандив тусламжаар ирсэн эм тарианууд нь хугацаа дуусаж, цаашид ашиглах боломжгүй болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн, “Үнэн ба зөв” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, хугацаа дуусан эмийн асуудлыг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2023 оны 9 дүгээр сарын 30-ны дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	1,000.0					1	1,000.0				
Дүн	1	1,000.0					1	1,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
ЭМЯ болон хандиваар ирсэн хугацаа нь дууссан болон цаашид ашиглагдахгүй болсон эм,эмийн хэрэгсэл, боох материал	1	282,556.3					1	282,556.3				
Тайлант онд тэтгэвэрт гарсан хүнийг гэрээний дагуу авч ажиллуулж байх хугацаанд ээлжийн амралтын тооцоог холбогдох хуулийн дагуу бодож олгоогүй	1	300.0	1	300.0								
Дүн	2	282,856.3		300.0			1	282,556.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд 159 мэдээлэл байршуулахаас 153 мэдээлэл байршуулж 4 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан 2 мэдээлэл хугацаа болоогүй	1						1	
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn